

Ш.Оюунханд

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,  
Социологийн ухааны доктор (Ph.D)

**ОРЧИН ҮЕД СОНГОДОГ ОНОЛЫН “КАНОНЧЛОЛ”-ЫГ ШҮҮН  
ТУНГААХ АСУУДАЛД**

**Abstract:** *In this article, the author analyzes continuity of application of sociological theories. Author makes distinction between classical and modern era of sociology and tries to elaborate the following aspects:*

- A. Ideas of classic theorists (Marx, Weber, Durkheim, Ziegler) on modern society;*
- B. Analytical judgment on contemporary approaches and tendencies to classical theorists;*
- C. Possibility of “Canonization” contemporary theorists’ ideas similar to classical theorists’ ideas.*

**Key words:** *“Canonization” of theories, classical theory, modern theory, analytical judgment, Contemporary Era*

- A. Сонгодогууд орчин үеийн нийгмийн тухайд
- B. Социологийн сонгодог үеийн “канончлол”-ын талаарх орчин үеийн эргэцүүлэл
- C. Орчин үед онолын канончлол боломжтой юу?

А.Эдүгээ шинжлэх ухааны хөгжил, түүн дундаа байгаль шинжлэлтэй харьцуулбал хүмүүсийн харилцаа, нийгмийн үзэгдэл үйл явцуудыг судлахдаа илүү “тодерант” арга зүйд суурилдаг нийгмийн шинжлэх ухааны хөгжилд асар их хэмжээний өөрчлөлт хувьслууд гарсаар байна. Энэ нь хүмүүсийн хоорондын нийгмийн харилцан үйлдэл, зан үйлийг судалдаг социологийн шинжлэх ухааны хувьд илүү тод мэдрэгддэг. Өнөөдөр хүмүүс өдөр тутмын амьдралдаа аливаа зүйлийг тусган авах, үнэлэлт дүгнэлт өгөхдөө аль нэг хамгийн шилдэг зүйлийг удирдлага болгох эсхүл өмнө нь хамгийн ойлгомжтой зүй ёсны мэт санагддаг зүйлийн талаар ч аксиом байдлаар хүлээн авах бус харин эргэцүүлэн боддог болжээ.

Шинжлэх ухааны хэвшмэл загвар, нэгэнт тогтсон дэг жаяг, бидний нэрийддэгээр онол парадигмуудын талаарх канончилсон мэдлэг нь танин мэдэхүйг системчлэх, онолын хөгжлийн түүх судлал талаасаа нэн ач холбогдолтой хэдий ч зөвхөн энэ хүрээгээр л бүх зүйлийг төлөөлөн ойлгох нь хувь хүний бүтээлч сэтгэлгээг хазаарлан, нийгмийн харилцааны нарийн ширийн зүйлүүдийг олж харах, эргэцүүлэх боломжийг хомсдуулдаг.

Австралийн Сиднейн их сургуулийн судлаач профессор Корнелл саявтархан “Социологийн сонгодогууд чухам юугаараа тийм сонгодог юм бэ? хэмээх хамгийн энгийн асуултаар өөрийн гайхан бахадсанаас илүүтэйгээр орчин үеийн байр сууринаас эргэцүүлсэн, асуудал дэвшүүлсэн санаатай өгүүлэл хэвлүүлсэн нь Европ төдийгүй дэлхийн социологид нэлээд хүчтэй сенсаци тарьж, эдүгээ эрдэмтдийн нийгэмлэг энэ талаар олон талт шүүмжлэл хэлэлцүүлгийг өрнүүлсээр байгаа билээ. Казакстанд болсон орчин үеийн социологичдын чуулга уулзалтанд миний бие оролцож байсан агаад чуулга уулзалтын үеэр төрсөн сэтгэгдэлээсээ үүдэн, тэрчлэн хэдэн жил социологийн онол сэтгэлгээний түүхийг сонирхон судалж, оюутнуудад зааж сургаж байсны хувьд, нэгэн үе Франц Германы сонгодогуудаар (Э.Дюркхайм, Г.Зиммель, М.Вебер) “өвчилж” орос орчуулгаар нь бус эх хэлээр нь уншиж бүрэн төгс ойлгож авах юмсан хэмээн санааширч явдаг байсны хувьд энэ талаарх хэдэн санаануудаа эвлүүлэн бичихийг оролдлоо. Гэвч энэ нь би олон жилийн итгэл үнэмшлээсээ няцан урваж байгаа юм уу эсвэл эдгээр судлаачдын оруулсан үлэмж хувь нэмрийг өчүүхэн төдий ч үгүйсгэх санаа агуулаагүй гэдгийг эрхэм социологичид та бүхэн эрх биш тунгаан ойлгох буй заа.

Социологийн онолууд нь нийгмийн хөгжлийн хэмнэлтэй салшгүй холбоотой төдийгүй, түүний бодит байдалд шинжилгээ хийн, прогнозчилох үүргийг хүлээдэг. Социологийн онолын үүднээс авч үзвээс орчин үеийн нийгэм нь модернизмоос постмодернизмд шилжих шилжилттэй холбоотой, шинэ шинэ онолын чиг баримжаа үүсэн, нийгмийн үйл явцын тайлбарлалд тусгалаа олж байна.

Постмодернист эрин үеийн онолын асуудлыг судлахад энэ талаарх сонгодог судлаачид ирээдүйн загвараа болгож байсан нийгмийн тухайд бичсэн үзэл бодол дэвшүүлсэн санаа оноо танин мэдэхүйн, харьцуулан шинжлэлийн үнэт материал болдог.

Түүн дундаа энэ чиглэлийн анализыг Маркс, Вебер, Дюркхайм, Зиммель нар орчин үеийн нийгмийн үүсэл хөгжил, доминант нөлөөллийн асуудлыг тусгайлан авч үзсэн байдаг. Тэд бүгд л орчин үеийн нийгмийн хөгжлийн олон давуу талыг авч үзсэн ч зохиол бүтээлүүддээ дийлэнхдээ, хөгжлийн үр дагавар, шинээр буй болгож байгаа “асуудлууд”-ын шүүмжид анхаарлаа хандуулдаг.

Маркс орчин үеийг капиталист эдийн засаг хэмээх ойлголтоор төлөөлүүлэн тайлбарлаж, эртний нийгмээс орчин үед шилжих шилжилтийн дэвшилтэт талууд, эдийн засгийн системийн гаж шинж (хүнийсгэл, мөлжлөг..) -үүдийн шүүмжлэлээр хязгаарладаг. Эцсийн дүндээ нийгмийн хувьсгал, эдийн засгийн капитал, харьцангуй хүчирхийллийн арга замыг арга зүйн үндэслэлээ болгодог.

Веберийн хувьд орчин үеийн нийгэмд формаль рациональчлал тархсанаар рациональчлалын энэхүү төмөр торлогийн үүсэл, үр дүн нь бусад хэв шинжүүдэд уршигтай байдалд хүргэсэн. Учир нь хүмүүс энэхүү төмөр торлогт хэт хүлэгдсэнээр хүмүүнлэг шинжүүдээ улам бүр алдсаар байна. Тэрээр, рационализмын өгөөжтэй ашигтай талуудыг хүлээн зөвшөөрч байсан ч түүнээс үүдэлтэй олон “асуудал” урган гардаг, түүнийг судлахыг чухалчилж байлаа.

Дюркхаймын үзлээр, орчин үеийн нийгэм нь органик эв нэгдэл, хамтач үзлийн сулралыг ихэсгэсэн. Наад зах нь нийтлэг ёс суртахуун задарснаар хүмүүс заримдаа “орчин үеийн” нийгэм дунд төөрсөн, хаягдмал хүүхэд мэт мэдрэхэд хүргээд байна. Тэд “аноми”-иос үүдэлтэй бэршээлүүдтэй тулгардаг хэмээн үздэг.

Зиммелийн хувьд асуудлыг арай өөр өнцгөөс нь авч үзэн судалсан байдаг. Түүнийг эдүгээ модернизм постмодернизмын хоорондын холбоо шүтэлцээг тайлбарлагч формаль чиглэлийн томоохон төлөөлөгч хэмээн үздэг. Зиммель орчин үеийн нийгмийг хот ба мөнгөний эдийн засаг хэмээх хоёр үндсэн ойлголтуудын зааг дээр авч үздэг нь ихээхэн сонирхол татдаг билээ. Хот нь орчин үе хэмээх ойлголтын төвлөрөл, харин мөнгөний эдийн засаг нь түүний тархалтын хүрээ тэлэлтийг судлах хэмжүүр болдог.

Зиммель “Мөнгөний философи” бүтээлдээ, орчин үеийг 3 өнцгөөр тайлбарладаг.

1. Модернизаци буюу орчин үеийн нийгмийн шинэчлэл нь, хүний хөгжил, нөөц бололцооны олон давуутай талуудыг нээх боломжийг олгосноороо өмнөх нийгмийн хэв шинжүүдээс ялгардаг.
2. Орчин үеийн нийгэм дэх мөнгөний хүчтэй нөлөөлөл урьд хожидоос илүү хүчтэй шинжтэй үйлчилж байна.
3. Орчин үеийн дээрх үндсэн шинжүүд нь “хүнийсгэл” бий болоход ихээхэн түлхэц үзүүлсэн, түүний үндсэн үр дагавар нь эерэгээсээ сөрөг, таагүй байдалд шууд нөлөөлсөн хэмээн үздэг. Үүгээрээ тэрээр социологийн үндсэн ойлголт болох “соёлын эмгэнэл” (объектив субъектив соёлын хагарал)-д хүргэсэн.

Фрисбигийн үзлээр, Зиммель, анхаарлаа орчин үеийн нийгмийн “туршлага”-д хандуулдаг. Түүний энэхүү туршлага, сургамжийн чухал элемент нь – цаг хугацаа, орон зай, тохиолдлын учир шалтгаан зэрэг ойлголтууд болно.

Хэдийгээр 1920 он гэхэд дээрх судлаачдын хэн нь ч амьд сэрүүн байхаа больсон, түүнээс хойш нийгэм маш их өөрчлөгдсөн хэдий ч сонгодогуудын орчин үеийн нийгмийн талаарх үзэл санаа нь онол арга зүйн ач холбогдол үнэ цэнээ алдаагүй, судлаачдын сонирхлын төвд оршоор байгаа билээ.

В.Социологийн сонгодог канончлолд орчин үеийн байр сууринаас хандах нь

Бид социологийн олон тооны ном зохиол сурах бичиг, гарын авлага, сэтгүүлүүдийн шүүн уншваас онолын түүх нь О.Конт, Э.Дюркхайм, Ж.Зиммель, Ф.Тённис, М.Вебер, П.А.Сорокин гэхийгээд л ерөнхийдөө өндөрлөх тийшээгээ ханддаг, заах арга зүй сургалтанд маань ч энэхүү загвар зонхилон үйлчилсээр ирсэн. Сайндаа л зарим номонд Сен Симон, Монтескье, Тард Парето, Зомбарт нарын нэр дурдагддаг.

Сүүлийн 30-аад жил, тодруулбал, 1980 оноос эхлэн сонгодог социологичдын онол, үзэл баримтлалыг туйлын үнэн, шавхагдашгүй универсаль ягшмал онол хэмээн үзэх үзэлд радикал шинжтэй өөрлөлт гарсан. Энэ үеийг социологийн орчин үеийн хөгжлийн шинэ эрин үе хэмээн судлаачид үздэг.

Сонгодог социологийн канон жагсаалт нь социологийн онолын түүхэнд нэрээ мөнхөлсөн Европийн модернизмын төлөөлөгчид, тэдний агуу ухаан санаатай салшгүй холбоотой яригддаг. Угтаа бол социологи нь өргөн цар хүрээтэй соёлын хөгжлийн динамик шинжид үндэслэн, либераль болоод их гүрний чиг хандлагуудын нарийн зөрчилдөөнийг цөм асуудлаа болгосоор ирсэн билээ. Глобаль чөлөөлөл, колончлол нь социологийн шинжлэх ухааны концептуаль суурь, нийгмийн баримтууд, судалгааны арга зүйн үндсийг бүрдүүлдэг. Яван явсаар XX зууны эхэн үеийн социологийн их хямралын дараагаар Америкт социологийн шинжлэх ухааны судалгааны үндсэн асуудал нь метрополийн дотоод дахь нийгмийн давалгаа, олон янзын байр суурь болон хувирсан билээ. Социологи дахь нэгэнт тогтсон, хэн тогтоосон нь үл мэдэгдэх энэхүү “канончлол” нь тодорхой хэмжээний соёлын заагийг үүсгэн, түүнийг заах арга зүй онолын түүхийн талаарх чимээгүй хүлээн зөвшөөрлийг үүсгэсээр ирсэн.

Орчин үед социологийн хаана ч бичигдсэн бай хамаагүй Америкт ч юм уу эсвэл дэлхийн шал өөр өнцөг буланд хэвлэгдсэн ч юм уу/ дурын сурах бичгийг аваад үзвэл бараг бүхий л тохиолдолд эхний хуудаснаас нь эхлээд л социологийг үндэслэгчдийн жагсаалт түүн дундаа К.Маркс, Э.Дюркхайм, М.Вебер нарын нэрсийг харж болно. Удиртгалын хэсэгт нь хууль юм шиг О.Конт, Г.Спенсер, Ж.Зиммель нарыг, зарим тохиолдолд удаахь бүлгийнхний түвшний төлөөлөгчид хэмээх утгаар нь Ф.Тённис, Ф.Энгельс, В.Парето, У.Г.Самнер, Ч.Х.Кули, Ж.Мид нарыг хальт авч үзсэн байдаг.

Энэ чиглэлээр их дээд сургуульд суралцагчдад, социологийн үндэслэгчид Европын нийгэм дэх драматик өөрчлөлтүүд, аж үйлдвэржилтийн хувьсгал, ангийн тэмцэл, секулярчлал, хүнийсгэл орчин үеийн нийгмийн модернизацийн эсрэг хариулт олох, эрэл хайгуул хийх үйл явдал байлаа хэмээн сургадаг. “Социологи нь юуны түрүүн шинэ аж үйлдвэржилтийн нийгмийн үр дагавар болсон шинжлэх ухаан юм” /Bottomore/. Энэхүү үзэл санаа нь магистрантур болон докторантурын программд ч ахисан түвшинд чиг хандлага нь үргэлжлэн давтагддаг. Америкийн социологид зайлшгүй судлах хөтөлбөрийн хүрээнд “сонгодог социологи”-ийг Маркс, Дюркхайм, Вебер нарын тодорхой бүтээлүүдийг судлах курс хэрэгждэг.

Аль ч улс орны сургалтын хөтөлбөр нь социологийн түүхийн судалгаанаас эхэлдэг агаад ерөнхийдөө л адил төлөөлөгчид, ойлголтоор дамжуулан социологид суралцдаг бичигдээгүй хууль үйлчилдэг ажээ. Үүнийг бид эерэг талаас нь дүгнэвээс социологийн институцилэлтэй холбон ойлгож тайлбарлаж болох юм. Жишээ нь, Swingewood “Социологийн сэтгэлгээний товч түүх” номондоо Британийн судлаачид эрдэмтдийн итгэл хүлээхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий бүтээлүүдийг 3-н үндсэн хэсэгт хуваан авч үзсэн. “Социологийн үндэс” / Конт, Маркс нарын бүтээлүүдтэй танилцах, бэлтгэл үе/, “Сонгодог социологи” /цөм асуудал нь Дюркхайм, Вебер, Маркс/, “Орчин үеийн социологи” хэмээн ангилсан. Энэхүү ангиллыг Munch 1994 онд Германд “сонгодог үе бол... социологийг үндэслэгчид социологийн онолыг бүтэцчилэх фундаментыг тавьсан үе юм” хэмээн тодорхойлжээ.

Социологичид социологийн түүхд хандах хандлагад шинжилгээ хийж үзвээс хэд хэдэн зүйл тод анзаарагддаг.

- сонгодог текстүүд, судалгааны ажил, нэг сэдэвт бүтээлүүд нь ихэнхдээ марксист арга зүй эсвэл Дюркхайм, Вебер нарын онолуудыг ашигласан байдаг.
- социологийн нэр хүнд бүхий сэтгүүлүүдэд социологийн онолын “одууд”-ыг олонтоо авч үзэх, тайлбарлах, /Social Theory Today/ орчин үеийн социологийн төлөөлөгчид ч “сонгодог социологи бол социологийн үндэс” хэмээх уриа лоозонгоор бүгд эхэлдэг. /Alexander 1978/. 1990-ээд оноос л эхлэн онолын суурь материалууд нь гүйцэтгэх үүргээ нэгэнт давуулан биелүүлсэн өнөөдөр цаашаа явах хэрэгтэй хэмээх үзэл нэг талаас, нөгөө хэсэг судлаачид нь сонгодог үеийн шедевр болсон бүтээлүүдийг улам бүр эргэн шинээр харах, түүнээс олон тооны шинэ зүйлүүдийг олж илрүүлэх хэмээх үзлүүд зэрэгцэн оршиж байна. Эдгээр үзлүүдийн тод илэрхийлэл нь Challenger 1994 онд Дюркхаймын социологийг Аристотелийн призмээр судлах, харин Lehman 1993 онд пост-пост-структуралист байр сууринаас Дюркхаймыг судлах г.м. олон байр суурь, онолын ба судалгааны загваруудыг санал болгодог. Kalberg 1996, Веберийг судлахдаа

түүний хэнд ч төдийлөн танил биш бүтээлүүдээр нь дамжуулан судлах, эсвэл түүнийг бусдаас онцгой, шинэлэг хандлагаар судлах нь зүйтэй хэмээн үздэг.

- Seidman тэргүүтэй социологичид сонгодог социологийн “канон” болон тэдгээрийн зохиол бүтээлийг хөндөшгүй дархан байдлаар авч үзэх, мөнхийн тавтологи болгон судлах нь суралцагсад танин мэдэхүйн ач холбогдолтой байх ч орчин үед шинээр эргэцүүлэх, шинэ байр сууринаас хандах, орчин үеийн нийгмийн хөгжлийн онцлогийг харгалзан үзэх шаардлага зүй ёсоор урган гарч ирж байна. Үүний сацуу социологийн “мартагдсан онолууд” нэр нь төдийлэн цууд гараагүй ч үзэл баримтлал нь нэн өвөрмөц орчин үеийн нийгмийн хөгжил, хүмүүсийн харилцааг тайлбарласан онолуудыг судлах хэрэгцээ бий болоод байна хэмээн үзэх хандлага илт мэдрэгдэж байна. Үүнтэй ч холбоотойгоор орчин үед социологийн сурах бичгийг туурвихдаа Дю Буа /Du Bois/, Джейн Адамс /Jane Adams/ болон бусад төлөөлөгчдийг оруулах нь зүйтэй хэмээх санаанууд гарсаар байна.

Дээрх бүхий л чиг хандлагууд үзэл бодлуудыг товч дүгнэвээс, өнгөрсөн үеийн түүх судлал нь чухал хэдий ч түүнийг хэрхэн ашиглах талд илүү анхаарах, сонгодог социологи, социологийн сэтгэлгээний түүхийг заах аргаа тодорхой хэмжээгээр шинэчлэх шаардлага гарч байна гэж хэлж болохоор байгаа юм. Гэсэн ч социологийн гарал үүслийн түүх, онолын төлөвшилд оруулсан хувь нэмрийг бүхэлд нь аваад үзвэл сэтгэл зовиноодог үндсэн 2 бүлэг асуудлууд байдаг.

1. Хэдийгээр сонгодог үе зарчмын хувьд үнэхээр томоохон нэр хүндтэй ч практик дээр дийлэнх социологийн судалгаанд ашиглагддаггүй. Олон тооны тоон арга, этнографик судалгаа нь “канончлогдсон” онол, түүгээр тодорхойлогддог асуудлуудад үндэслэгдэн ишлэгддэггүй. Энэхүү байдал нь зарим судлаачдыг сонгодог онол өнөөдөр аль хэдийнэ давамгайлах шинж чанараа /релевант/ алджээ хэмээх үзлийг баримтлахад хүргэдэг. Нөгөө хэсэг нь сонгодог судлаачид тэдгээрийн онолыг цэвэр “бэлгэдлийн” функцтэй, үндсэндээ мэргэжлийн социологичдын “эв нэгдлийн ритуал” болжээ хэмээн дүгнэхэд хүргэдэг.
2. “Сонгодог үеийн” хэмээгдэх зарим социологичид наад зах нь Франклин Генри Гиддингс /1896/ алдарт Колумбийн их сургуулийн анхны профессор, өөрийн “Социологийн үндэслэл” /The Principles of Sociology/ хэмээх бүтээлээ хэвлүүлэхдээ ч түүний үндэслэгчийг Адам Смит хэмээн үзсэн байдаг. Виктор Бранфорд /1904/ Лондонд болсон социологийн их хурал дээр “социологийн үндэслэгчид” илтгэлдээ социологийн гол үндэслэгч нь Кондорс хэмээн тодорхойлсон. Дюркхайм, Вебер нарыг залгамжлагчид ч тэднийг агуу хэмээн үздэггүй байсан агаад Марксын бүтээлийг огт ач холбогдолтой хэмээн үздэггүй байсан ажээ.

Социологийн түүхийг аваад үзсэн ч өмнө нь “сонгодог” хэмээх нэр томъёо нь орчин үеийнх шиг утга агуулгаар ойлгогддоггүй байсан байна. Шинэ онол үзэл баримтлалыг дэвшүүлж буй судлаачид ч Контыг ишлэхдээ “Социологи” хэмээх нэр томъёог үндэслэгч, харин Ч.Дарвинийг эволюцийн чиглэлийг үндэслэгч утгаар нь ойлгож тайлбарладаг байв.

Лестер Уорд “Динамик социологи” /Dynamic Sociology/-ийн судлах зүйлийг 1883 онд хэвлүүлсэн анхны хэвлэлдээ “Социологи” хэмээх нэр томъёо нь өргөн хэрэглэгддэггүй байсныг тэмдэглэсэн. Дараагийн 10-н жилд нь “социологи”-ийг олон тооны шинэлэг хэлбэрийн судалгаанууд өргөн дэлгэр хэрэглэгдэх түгээхэд асар чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ чиглэлээр гарсан эрдэм шинжилгээ, судалгаа, сэтгүүл, их дээд сургуулийн сургалт зэрэг нь хэрэв биологи нь XIX зуунд манлайлагч шинжлэх ухааны үүрэг гүйцэтгэж байсан бол социологи нь XX зууны хамгийн тэргүүлэгч шинжлэх ухаан болохыг баталж чадсан. /Ward 1897/. Уорд шинэ тулгар хөгжиж буй социологи хэмээх шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан 37 судлаачийн нэрсийн жагсаалтыг гаргахад түүнд Дюркхайм, Тённис нар багтсан ч Маркс, Вебер нар багтаагүй байдаг аж. Сонгодог төлөөлөгчид гэж хэн болох түүний шалгуур нь юу болох, хүлээн зөвшөөрөгдөх шинжийг нь хэрхэн тодорхойлох олон асуудлууд эргэлзээтэй шинжийг агуулж буйг илэрхийлж байгаа олон тооны жишээг дурдаж болох юм.

1920 он гэхэд “сонгодог” хэмээн ойлголтын талаарх нэгдмэл нэг утга санаа бүхий санаа бодол үгүй, тусгайлан судлах талаарх тодорхой зүйл үгүй болсон.

Дүгнэж үзвээс, “канончлогдсон” утга гэхээсээ нэвтэрхий толь буюу “энциклопеди” утга санаа илүүтэй илэрхийлэгддэг. Энциклопедизмын зарчмыг Парсонсоос бусад бүхий л

судлаачид дэмжиж байсан. П.Сорокин Америкт Европын шинжлэх ухааны сэтгэлгээг танилцуулагч гүүр болж байсны хувьд “Орчин үеийн социологийн онолууд” хэмээх бүтээлдээ /1928/ Ле Пле, Брюн, Гальтон, Костэ, Гумплович, Петражецкии, Парето, Дюркхайм, Маркс болон өөр олон судлаачдыг оруулж өгсөн байдаг.

Мэдээжээр, орчин үеийн социологид сонгодог үеийн канончлол, түүний учир шалтгаан, ач холбогдлыг тайлбарлахад түүний бүрдүүлбэр хэсгүүд, судлаачдын хувийн үнэлэмж, нэр хүндийн бүдгэрэл, тодрол, нөлөөллийн өсөн нэмэгдэж байгаа байдал зэрэг нь учир дутагдалтай хүчин зүйл болно. Бид цаашдаа социологийн түүхийг хамтын хөдөлмөрийн бүтээгдэхүүн, нийтлэг асуудал, сонирхол, социологийг өдий хэмжээнд байлгахад нөлөөлсөн цаг хугацаа, орон зай, түүхэн болон улс төр, нийгмийн хүчин зүйлүүдтэй холбон судлах нь гарцаагүй.

Дээрх бүхий л хүчин зүйлүүдийг харгалзан үзэж сонгодогуудын канончлолд эргэлзээтэй хандаж болох мэт.. Өнөөгийн өндөрлөгөөс эргэн харахул, хүйсийн, арьсны, шашны зэрэг хэд хэдэн шинжүүдээр бидний тархи толгойд шингэсэн канончлолыг шүүмжлэн эргэцүүлэх боломжтой.

1. Нэн түрүүнд дээр дурдсан канонд яагаад зөвхөн цагаан арьстан судлаачид багтдаг юм бэ? Энэ нь хар шар арьстангууд социологи нийгмийн хөгжлийн талаарх түүхэн эргэцүүллийн талаар ямар нэг эргэцүүлэл, санаа оноо үзэл бодлоо илэрхийлж байгаагүй гэсэн үг үү гэвэл олон тооны сурвалж ишлэлүүдээс үзвэл хараахан тийм бус юм. Жишээлэн дурдвал, Дубойз (Америкийн коммунист, XIX-XX зууны Африк-Америкийн социологич, марксист онолын төлөөлөгч, арьсны өнгөр ялгаварлах үзэл), М.Фуко (Франц), Сайд (Алжир), Фанон (Палестин), Абдул Ибн Рахман, Төв Азиас доголлон Төмөр, То ван гэх мэт.

2. Хүйсийн хувьд аваад үзвэл дээрх канонд эмэгтэй судлаачдын нэр огтоос байдаггүй. Гэтэл нарийвчилсан судалгаа хийгээд үзвэл, харин ч нийгмийн харилцааны тэгш бус байдал, шударга ёс, нийгмийг энэрэнгүйжүүлэх үйлсэд эмэгтэйчүүд хүчин зүйтгэж санаа оноогоо илэрхийлж байсан жишээ цөөнгүй. Тухайлбал, (Маргарет Мид, Мариана Вебер, Мартина Хариот, Шарлет Перкинс Гилман.) М.Веберийн бүтээлүүдийн хамгийн шилмэл, гайхалтай санаа оноог эхнэр нь гарган, түүний бүтээлүүдийг баяжуулан редакторлодог байсныг Вебер өөрөө ч цохон тэмдэглэсэн байдаг.

3. Шашны итгэл үнэмшлийн үүднээс аваад үзвэл бидний шүтэн биширдэг судлаачид бүгд л Христийн шашны үнэн сүсэгтнүүд бус ч энэ л шашны төлөөлөгчид байдаг. /О. Конт “Хүн төрөлхтөн нэгэн дээвэр дор”, Э.Дюркхайм “Шашны амьдралын энгийн хэлбэрүүд”, М.Вебер “Протестант ёс зүй ба капитализмын үзэл санаа” бүтээлүүд нь социологийн шилмэл санд зүй ёсоор ордог. Харин эдгээр бүтээлүүдэд христийн шашныг илэрхий бахдан дуулаагүй ч хүн төрөлхтөн дэвшилд хүрэх замыг чухамхүү энэ л шашинтай холбодог нь хэнд ч ойлгомжтой байдаг. Шашны энэхүү доминант өнгө аясыг ч судлаачид орчин үеийн байр сууринаас шүүмжлэлтэй ханддагийн тод жишээ нь С.Хантингтоны соёлын мөргөлдөөний зарчимд тусгалаа олсон байдаг.

С. Орчин үеийн социологичид тэдний үзэл баримтлал нь өнөөдөр нийгмийн өмнө бодитоор тулгараад буй асуудлуудыг хүмүүсийн өдөр тутмын харилцаагаар дамжуулан судлахад чиглэгдэж байгаа гэдэг утгаараа нэлээд шинэлэг, тулгамдсан хэдий ч тэд онолын хувьд хэзээ ч өмнө нь байгаагүй цоо шинэ зүйлээс гараагаа эхэлдэггүй. Дийлэнхдээ өмнө нь боловсрогдсон үзэл баримтлал, онол арга зүйд тулгуурлан, тайлбарлал хийх, бүтээлчээр эргэцүүлэн тунгаах, зарим тохиолдолд өөрсдөө ч мэдэлгүй рефлексийн хүрээнд баталгаа нотолгоондоо сонгодогуудаас ашигладаг. Учир нь сонгодог социологичдын онол концептууд нь онол арга зүйн уламжлалыг бүрдүүлэхийн сацуу автоматаар бидний оюун ухаан, ой тойнд хадгалагдан үлдсэн байдаг учраас л бид өдөр тутмын амьдрал, орчин үеийн нийгмийн харилцаанд дүн шинжилгээ хийх, үндэслэх, учир шалтгааны тайлбарлалыг олж тогтоохдоо тархи толгойдөө шингэсэн сонгодог загваруудыг ашигласан байдаг.

Тэртээ нэгэн цагт, одоогоос 150-аад жилийн тэртээ О.Конт социологи хэмээх нэр томъёог ШУ-ны эргэлтэнд оруулж ирэн, харьцангуй автономит шинжтэй оршигч ШУ хэмээн тодорхойлсон билээ. Түүхийн он удаан жилийн хүрдэн тойрогны үүднээс авч үзвэл энэ нь төдийлөн урт хугацаа биш ч энэ хугацаанд социологи нь статусын, онол арга зүйн, арга техникийн, нийгмийн хэрэглээний хувьд үлэмж их зүйлийг амжуулж, нэгэнт академик түвшний ШУ болтлоо хөгжжээ. Үүнд социологичдын сонгодог болон орчин үеийн төлөөлөгчдийн оюун

санаа бүтээл туурвил, үйл ажиллагааны залгамж холбоо үнэлж баршгүй чухал үүрэг гүйцэтгэсэн нь ойлгомжтой.

“Орчин үе” хэмээх ойлголт нь өөрөө байнга өөрчлөгдөн хөгжиж байдагтай холбоотойгоор эдүгээ 60-70-аад оны үе нь сонгодог үетэйгээ харьцуулбал орчин үе, 90-ээд онтойгоо харьцуулбал социологийн онолын хөгжлийн сонгодог үе буюу түүх болох жишээтэй. Тэр ч утгаараа аль ч үеийн хувьд онолын бүрэн төгс боловсорсон схемийн талаар ярих нь зүйд нийцдэггүй агаад хөндөн тавьж ирсэн, хөндөн тавьж байгаа асуудлууд нь дийлэнхдээ нээлттэй, асуудал дэвшүүлсэн, санал болгож буй хувилбар байдлаар яригддаг. Нэн ялангуяа орчин үеийн социогичид, судлаачдын хувьд энэ нь онолын аль нэг загварт ягштал баригддаггүй, цаг хугацаа, орон зай, цуглуулсан туршлага, түүхэн нөхцөл байдал, үүсэн буй болоод байгаа нөхцөл байдлуудад уян хатнаар хандах, мэдрэмжтэй байх, харьцуулах, өөрийн үнэлэмж дүгнэлтийг бусдад тулгахгүй байх бололцоог олгодгоороо давуутай. Тод жишээ нь өнөөдөр хэвлэгдэн нийтлэгдэж байгаа бүтээл, нийтлэлүүд дэх багш, судлаачдын дэвшүүлж буй хувилбарууд нь ч тухайн зохиогчийнхоо хувьд “эргэлзээгүй” туйлын шижийг агуулдаггүй.

Орчин үеийн социологи нь канончлох боломжгүй. Зөвхөн харьцангуй болзмол байдлаар л орчин үеийн социологи дахь сонгодогууд /60-70-аад он/-ын хүрээнд л мэргэжлийн бүтээл нийтлэл, ном зохиол нь хэр академик хүрээнд хэр танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн, бусадтай харьцуулбал ямар давуу талуудтай, хэвлэн нийтлүүлсэн зохиол бүтээл ном нь энэ чиглэлийн сургалтанд хэр хэрэгцээтэйгээр ашиглагдаж байгаа, их дээд сургуулийн багш, судлаачид зохиогчийн мэргэшсэн мэдлэгийн талаарх үнэлэмж зэрэг цөөн тооны шалгуураар л тодорхойлогдож болох талтай.

Социологийн сэтгэлгээний түүхийн нэгэн адил орчин үеийн социологичдын легитим шинжтэй он дараалсан товчооныг гаргах боломжгүй. Учир нь орчин үеийн социологийн онолыг системчлэх асуудал туйлын хүндрэлтэй гагцхүү онол арга зүйн чиг баримжааны тэргүүлэх шинжээр нь түвшингээр нь л макро, микро, интеграль хэмээх хандлагуудыг шалгуур болгох нь зүйтэй болов уу.